

**ШИНЖЭЭЧДИЙН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨСӨӨЛӨЛ**  
**(2024 оны IV улирлын түүвэр судалгааны тайлан)**

**Судалгааны товч үр дүн**

Шинжээчдийн макро эдийн засгийн төсөөллийн судалгааг 2024 оны 11-р сарын 20-29-ний өдрүүдийн хооронд банкуудын эдийн засагчид, их дээд сургуулиудын багш нар, судалгааны болон үнэт цаасны компаниудын нийт 22 шинжээчийн дунд явуулж, судалгааны үр дүнг дараах байдлаар нэгтгэн танилцуулж байна.

**Шинжээчид:**

**2024 оны IV улиралд**

- Инфляц бага зэрэг нэмэгдэж 7.5%,
- Эдийн засгийн өсөлт 5.5%,
- Бодлогын хүү өнөөгийн түвшинд 10.1%,
- Зээлийн хүү өнөөгийн түвшинд 16.9% гэж таамагласан байна.

**2025 оны III улиралд**

- Инфляц нэмэгдэж 8.4%,
- Эдийн засгийн өсөлт 6.2%,
- Бодлогын хүү бага зэрэг нэмэгдэж 10.8%,
- Зээлийн хүү өнөөгийн түвшинд 16.9% гэж таамагласан байна.

**Судалгааны нэгдсэн үр дүн**

Огноо	2024 он 10 сар	2024 он IV улирал	2025 оны III улирал
Инфляц /ХҮИ-ийн жилийн өсөлт, УБ хот, %/	7.0%	7.5%	8.4%
Эдийн засгийн өсөлт /Бодит ДНБ-ий жилийн өсөлт, %/	5.0%*	5.5%	6.2%
Төв банкны бодлогын хүү /%/	10.0%	10.1%	10.8%
Олгосон зээлийн дундаж хүү /₮, %/	17.0%	16.9%	16.9%

\* 2024 оны 3-р улирал


*Энэхүү улирал тутмын түүвэр судалгааны тайлангийн агуулга нь зөвхөн банкууд, хувь шинжээч, судлаачдын таамаглалыг нэгтгэсэн үр дүнг илэрхийлэх бөгөөд Монголбанкны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.*

© МОНГОЛБАНК, 2024

## I. Инфляц


2024 оны III улиралд Улаанбаатар хотын жилийн инфляц 7.0% болж нэмэгдсэн бөгөөд энэ нь өмнөх улирлын шинжээчдийн таамаглалын дунджаас 0.9 нэгж хувиар дээгүүр гарсан байна. Шинжээчид 2024 оны IV улиралд инфляц 7.5%, жилийн дараа 8.4% болно гэж таамаглаж байна (Зураг 1).

**Зураг 1. Инфляцын таамаглал**




Шинжээчдийн инфляцын таамаглалын тархалтыг авч үзвэл 2024 оны IV улиралд инфляц 7.0-7.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 35.9%-тай байна. Өмнөх улирлын судалгаагаар 2024 оны IV улиралд инфляц 6.0-6.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 32.5% гэж таамаглаж байжээ (Зураг 2).

**Зураг 2. Инфляцын таамаглалын тархалт /2024 оны IV улирал/**




Энэ удаагийн инфляцын таамаглалын үр дүнг өмнөх түүвэр судалгаануудын таамаглалуудтай харьцуулахад эргэн өсөж эхэлсэн бөгөөд цаашид мөн адил бага зэрэг өсөх хандлагатай байна. Шинжээчид 2024 оны IV улирлын инфляцыг өмнөх улирлын судалгаагаар 6.6% гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 7.5% гэж таамаглажээ (Зураг 3).

**Зураг 3. Инфляцын өмнөх таамаглалуудын харьцуулалт**



Инфляцын таамаглалыг тоон хариултын дунджаас гадна тоон хариултын медиан болон таамаглалын тархалтын дундаж утгаар тооцон үзэхэд дундажтай адилхан түвшинд буюу 7.5% байна (Зураг 4).


**Зураг 4. Ирэх улирлын инфляцын таамаглал /2024 оны IV улирал/**



## II. Эдийн засгийн өсөлт


2024 оны III улиралд бодит ДНБ-ий жилийн өсөлт 5.0% гарсан бөгөөд энэ нь өмнөх улирлын шинжээчдийн таамаглалын дунджаас 0.9 нэгж хувиар бага гаржээ. Шинжээчид бодит ДНБ-ий жилийн өсөлт 2024 оны IV улиралд 5.5%, 2025 оны III улиралд 6.2% гэж таамаглаж байна (Зураг 5).

**Зураг 5. Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглал**




Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалын тархалтыг авч үзвэл 2024 оны IV улиралд 5.0-5.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 37.9% байна. Өмнөх улирлын судалгаагаар 2024 оны IV улиралд өсөлт 6.0-6.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 27.5% гэж таамаглаж байжээ (Зураг 6).

**Зураг 6. Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалын тархалт /2024 оны IV улирал/**




Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалыг өмнөх түүвэр судалгаануудын таамаглалуудтай харьцуулахад буурсан бөгөөд цаашид бага зэрэг өсөх хандлага ажиглагдаж байна. Шинжээчид 2024 оны IV улирлын бодит ДНБ-ий жилийн өсөлтийг өмнөх улирлын судалгаагаар 5.8%-д хүрнэ гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 5.5% байна гэж таамаглажээ (Зураг 7).

**Зураг 7. Бодит ДНБ-ий өсөлтийн өмнөх таамаглалуудын харьцуулалт**



Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалыг тоон хариултын медиан болон таамаглалын тархалтын дундаж утгаар тооцон үзэхэд дундажтай ойролцоо түвшинд буюу 5.4-5.5% орчимд байна (Зураг 8).


**Зураг 8. Ирэх улирлын бодит ДНБ-ий өсөлтийн таамаглал /2024 оны IV улирал/**



### Ш. Бодлогын хүү


Шинжээчид төв банкны бодлогын хүүг 2024 оны IV улиралд дунджаар 10.1%, хамгийн ихдээ 11.0%, хамгийн багадаа 9.5% гэсэн хүлээлттэй байна. Цаашид бодлогын хүү өнөөгийн түвшнээс бага зэрэг өсөж 2025 оны III улиралд 10.8% байна гэж таамаглажээ (Зураг 9).

**Зураг 9. Бодлогын хүүний таамаглал**



Бодлогын хүүний таамаглалыг тархалтаар нь авч үзвэл шинжээчдийн дийлэнх нь 2024 оны IV улиралд бодлогын хүү 10.0% байна гэсэн таамаглалтай байна (Зураг 10).


**Зураг 10. Бодлогын хүүний таамаглалын тархалт /2024 оны IV улирал, хариултын тоогоор/**



2022 оны эхэн үеэс үнийн өсөлтийг хязгаарлах зорилгоор бодлогын хүүг аажмаар нэмэгдүүлсээр мөн оны эцэст 13% хүргэсэн бол 2024 оны 3 сараас бодлогын хүүг бууруулж, өнөөгийн байдлаар 10%-д хүргээд байна. Үүнтэй холбоотойгоор сүүлийн 3 улирал дараалан шинжээчдийн таамаглал буурах

хандлага ажиглагдлаа. Өмнөх 2 улирлын судалгаагаар шинжээчид 2024 оны IV улирлын бодлогын хүүг 11.0% байна гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар өнөөгийн түвшинд 10.1% байна гэж таамаглажээ (Зураг 11).


**Зураг 11. Бодлогын хүүний өмнөх таамаглалуудын харьцуулалт**



### IV. Зээлийн хүү


Шинжээчид төгрөгийн шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүүг 2024 оны IV улиралд дунджаар 16.9%, хамгийн ихдээ 17.2%, хамгийн багадаа 16.2%-тай байна гэж таамаглажээ. Цаашид зээлийн хүү өнөөгийн түвшинд хэвээр 16.9% орчим байхаар таамагласан байна (Зураг 12).

**Зураг 12. Зээлийн хүүний таамаглал**



Зээлийн хүүний таамаглалын тархалтаас харвал 2024 оны IV улиралд зээлийн жигнэсэн дундаж хүүг 16.7-17.0% байна гэсэн таамаглал давамгайлж байна (Зураг 13).

**Зураг 13. Зээлийн хүүний таамаглалын тархалт /2024 оны IV улирал, хариултын тоогоор/**



Энэ удаагийн зээлийн хүүний таамаглал нь өмнөх түүвэр судалгаануудын үр дүнгээс бага зэрэг өндөр түвшинд, хэвээр хадгалагдах хандлага ажиглагдаж байна. Сүүлийн улирлуудад шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү харьцангуй тогтвортой байгаа

боловч өмнөх улирлуудын таамаглал буурах төлөвтэй байсан бол энэ улирлын судалгаагаар харьцангуй өндөр гарлаа. Тухайлбал, өмнөх улирлын судалгаагаар шинжээчид 2024 оны IV улиралд зээлийн хүүг 16.2% гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 16.9% гарна гэж үзсэн байна (Зураг 14).

**Зураг 14. Зээлийн хүүний өмнөх таамаглалуудын харьцуулалт**

